Мал эмнэлгийн ерөнхий газрын даргын
2022 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн
А/169 дүгээр тушаалын 18 дугаар хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг батлагсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Мал эмнэлгийн ерөнхий газар | Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газар |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Өвчний оношилгоо, тандалт, мал эмнэлгийн лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-6 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдрийн 8 цаг | Баянзүрх дүүрэг Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын бодлого, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оношилгооны чадавх, бэлэн байдлыг хангах, төлөвлөх, зохион байгуулах, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, үр дүнг мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Төрийн албаны зөвлөлийн
2022 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн
537 дугаар тогтоолын 14 дүгээр хавсралт

# АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

## I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☑ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

| Байгууллагын нэр: | Нэгжийн нэр: |
|---|---|
| Мал эмнэлгийн ерөнхий газар | Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газар |

| Албан тушаалын нэр: | Албан тушаалын ангилал, зэрэглэл: |
|---|---|
| Өвчний оношилгоо, тандалт, мал эмнэлгийн лабораторийн асуудал хариуцсан мэргэжилтэн | Дэс түшмэл, ТЗ-6 |

| Ажлын цаг: | Ажлын байрны албан ёсны байршил: |
|---|---|
| Ажлын өдрийн 8 цаг | Баянзүрх дүүрэг Энхтайваны өргөн чөлөө 16а, Засгийн газрын IX байр |

| Хөдөлмөрийн нөхцөл: | Онцгой нөхцөл: |
|---|---|
| Хэвийн | Хамаарахгүй |

## II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Салбарын бодлого, хууль тогтоомж, стандартын хэрэгжилтийг хангуулах, мал эмнэлгийн сүлжээ лабораторийн оношилгооны чадавх, бэлэн байдлыг хангах, төлөвлөх, зохион байгуулах, мэргэжил аргазүйн удирдлагаар хангах, үр дүнг мэдээлэх чиг үүргийг хэрэгжүүлж гүйцэтгэлийн үр дүнг газрын даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилго:

1.Салбарын бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийн дүнг нэгтгэн гаргах.

2.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лаборатори, аймаг, нийслэлийн мал эмнэлгийн лабораториудын оношилгоо, шинжилгээний чадавхыг дээшлүүлэх, шаардагдах оношлуур, эм урвалж, багаж хэрэгслээр хангах, оношилгоо, шинжилгээний бэлэн байдлыг бүрдүүлэх.

3.Малын гоц халдварт, халдварт, шинээр болон дахин сэргэж байгаа өвчнүүд, халдваргүй өвчин, эндемик, онош тодорхойгүй болон хордлогот өвчнийг оношлох арга хэмжээг төлөвлөх, зохион байгуулах, тандалт, судалгааны дүнг нэгтгэн мэдээлэх, тайлагнах.

4.Хууль тогтоомжоор хүлээсэн бусад чиг үүргийг хэрэгжүүлэх.

| Зорилт | Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т Хариуцан гүйцэтгэх - Г Хянах - Х Шийдвэрлэх -Ш |
|---|---|---|---|
| 1 дүгээр зорилтын хүрээнд | 1.Салбарын хууль тогтоомж, мал, амьтны эрүүл мэндийн талаар төрөөс баримталж буй бодлогыг хэрэгжүүлж ажиллах; | Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 2.УИХ, Засгийн газрын шийдвэр, Сайдын тушаал бусад эрх зүйн актуудын хэрэгжилтийг хангуулах, хамтран ажиллах; | Эрх зүйн актуудын хэрэгжилт хангагдсан байна. | Г |
| | 3.Салбарын хууль, тогтоомжийг сурталчлах, иргэн, хуулийн этгээдийг зөвлөгөө, мэдээллээр хангах; | Зөвлөгөө, мэдээллээр хангасан байна. | Г |
| | 4.Хууль тогтоомж, тогтоол, тушаал, шийдвэр, бусад эрх зүйн актуудын хэрэгжиж байгаа практикийг судлах, боловсронгуй болгох санал боловсруулж холбогдох байгууллагад хүргүүлэх. | Санал боловсруулж хүргүүлсэн байна. | Г |
| | 1.Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лабораторийн оношилгоо шинжилгээний чадавхыг сайжруулах, шаардагдах эм урвалж, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмжөөр хангах, материаллаг баазыг бэхжүүлэх, өндөр мэдлэг, боловсролтой боловсон хүчний хангамжийг нэмэгдүүлэх замаар оношилгоо шинжилгээний үнэн бодитой, | Мал эмнэлгийн лабораторийн чадавх дээшилж, лабораторийн сүлжээ бий болж, оношлогоо, шинжилгээг олон улсын түвшинд хүргэж, гоц халдварт, халдварт болон бусад өвчнийг цаг алдалгүй оношлох, | Г |

| | | | |
|---|---|---|---|
| | шуурхай, баталгаатай байдлыг хангах, олон улсын түвшинд хүргэх; | Тандалт шинжилгээний дүнд үнэлэлт дүгнэлт өгөх | |
| 2 дугаар зорилтын хүрээнд | 2.Мал эмнэлгийн эмийн сорилт, баталгаажуулалтын улсын лабораторийн үйл ажиллагааны чадавхийг бэхжүүлэх, шаардлагатай багаж хэрэгсэл, эм урвалж, стандарт бодисын хангамжийг дээшлүүлэх, мал эмнэлгийн зориулалттай эм бэлдмэлд чанарын шалгалт хийх, арга зүйг олон улсын стандартад нийцүүлэх, найдвартай, баталгаатай, чанартай эмээр мал эмнэлгийг хангах нөхцөлийг бүрдүүлэх; | Олон улсын стандартад нийцсэн, баталгаатай эмээр мал эмнэлгийг хангах нөхцөлийг бүрдүүлсэн байна. | Г |
| | 3.Эрхэлсэн ажлын хүрээнд бараа, ажил, үйлчилгээний худалдан авалтын үйл ажиллагааг хариуцан ажиллах; | Худалдан авах үйл ажиллагаанд оролцсон байна. | Г |
| | 4.Лабораторийн оношилгоо, шинжилгээний талаар улсын нэгдсэн судалгаа, лабораторийн боловсон хүчний нөөц, ур чадвар, орчин нөхцөл, ажлын байрны судалгаа гаргах, шинэчлэх; | Судалгаа хийж ажилласан байна. | Г |
| | 5.Аймаг нийслэл, орон нутгийн лабораториудыг итгэмжлэлд хамруулах (MNS ISO 17025:2018) холбогдох стандартуудыг хангуулах, түвшинг дээшлүүлэх. | Стандартуудыг хангуулж, түвшинг дээшлүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Г |
| 3 дугаар зорилтын хүрээнд | 1.Малын гоц халдварт, халдварт, шинээр болон дахин сэргэж байгаа өвчнүүд, шимэгчтэх, халдваргүй өвчин, эндемик, онош тодорхойгүй болон хордлогот өвчнийг оношлох, тандалтын арга хэмжээг зохион байгуулах; | Холбогдох арга хэмжээг авч өвчнийг оношлох, тандалтын арга хэмжээг зохион байгуулсан байна. | Г |
| | 2.Өвчний тандалт, судалгааны арга хэмжээг олон улсын жишигт нийцүүлэх, Улсын мал эмнэлэг, ариун цэврийн төв лаборатори, Мал эмнэлгийн хүрээлэнтэй хамтран ажиллах, мэдээ, мэдээллийн чанарыг сайжруулах, дүнг нэгтгэн мэдээлэх, үр дүнг лабораторийн шинжилгээгээр баталгаажуулах; | Өвчний гаралт тархалтын тандалт, эпидемиологийн судалгааны арга хэмжээг олон улсын жишигт нийцүүлсэн байна. | Г |

МОНГОЛ УЛС ... ЗОВШООРОВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | | |
|---|---|---|---|
| | 3.Өвчний халдварын хүрээ тогтоох, эрүүлийг баталгаажуулах, вакцины мониторинг тандалтын арга хэмжээг улсын хэмжээнд төлөвлөх, хэрэгжүүлэх, зохион байгуулах; | Тандалтын арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Г |
| | 4.Аймаг, нийслэл, хүнсний захын мал эмнэлгийн лабораториудын чадавхийг бэхжүүлэх, био аюулгүй байдлыг хангах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, сургалт зохион байгуулах, мэдээллээр хангах; | Лабораториудын чадавхийг бэхжүүлэх, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна. | Г |
| | 5.Орон нутгийн лабораториудыг сар, улирал, хагас бүтэн жилийн тоон болон бичмэл тайлан мэдээг нэгтгэх, түүнд үндэслэн арга хэмжээг төлөвлөх. | Тайлан мэдээг нэгтгэж, холбогдох арга хэмжээг төлөвлөж хэрэгжүүлсэн байна. | Г |
| 4 дүгээр зорилтын хүрээнд | 1.Байгууллагын дотоод зохион байгуулалтын үйл ажиллагаанд идэвх, санаачлагатай оролцох; | Дотоод ажилд оролцсон байна. | Г |
| | 2.Дээд шатны байгууллага, удирдлагаас гаргасан шийдвэр, хурал, зөвлөгөөнөөс өгөгдсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх, эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр байгуулагдсан ажлын хэсэгт орж ажиллах; | Төрийн үйлчилгээг чанартай, түргэн шуурхай хүргэж ажилласан байна. | Г |
| | 3.Төрийн захиргааны албан хаагчийн албан үүргээ гүйцэтгэхдээ хууль тогтоомж, дүрэм, журам, ёс зүйн хэм хэмжээг дагаж мөрдөх; | Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг мөрдлөг болгосон байна. | Г |
| | 4.Салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх тайлан, мэдээ, судалгааг холбогдох дээд шатны байгууллага, удирдлагад хүргүүлэх; | Тайлан, мэдээг цаг хугацаанд нь хүргүүлсэн байна. | Г |
| | 5.Төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж биелэлт, хэрэгжилтийг тайлагнах; | Гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулсан байна. | Г |
| | 6.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу заасан хугацаанд архивт хүлээлгэн өгөх. | Архивын ажлын үндсэн заавартай нийцсэн байна. | Г |
| **III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА** | | | |

МОНГОЛ УЛС ... ЗОВШООРОВ ... ТӨРИЙН АЛБАНЫ ...

<table>
<tr><td>Боловсрол</td><td colspan="2">Бакалавр болон түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.</td></tr>
<tr><td>Мэргэжил</td><td colspan="2">- мал эмнэл зүй /084101/;<br>- малын их эмч.</td></tr>
<tr><td>Мэргэшил</td><td colspan="2">Төрийн албанд мэргэшүүлэх зохих багц сургалтад хамрагдаж төгссөн байх.</td></tr>
<tr><td>Туршлага</td><td colspan="2">Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.</td></tr>
<tr><td rowspan="4">Ур чадвар</td><td>Дүн шинжилгээ хийх</td><td>- албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг цуглуулж харьцуулах, дүгнэх, санал боловсруулах;<br>- мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг боловсруулах;<br>- бодлогын үндэслэлтэй санал, дүгнэлт, зөвлөмжийн төсөл боловсруулах, тайлагнах;<br>- судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх;<br>- төрийн өмчийн сүлжээ лабораториудыг мэргэшил, арга зүйн удирдлагаар хангах;<br>- бусад.</td></tr>
<tr><td>Асуудал шийдвэрлэх</td><td>- ашиг сонирхлын зөрчлөөс ангид, шударга байх;<br>- тулгамдсан асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулах;<br>- хуульд нийцсэн, оновчтой, үр дүнтэй шийдлийг шуурхай гаргах;<br>- аливаа үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөг урьдчилан харах чадвартай байх;<br>- хууль эрх зүйн үндэслэл бүхий зөвлөгөө өгөх чадвартай байх;<br>- удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх;<br>- бусад.</td></tr>
<tr><td>Багаар ажиллах</td><td>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, хамтран ажиллах;<br>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;<br>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;<br>- ёс зүйн хэм хэмжээг сахиж, зарчимч, тууштай, ажил хэрэгч чанараараа бусдыг үлгэрлэх;<br>- үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;<br>- бусад.</td></tr>
<tr><td>Бусад</td><td>- Сургалт, оношилгоо, судалгааны байгууллагад ажилласан туршлагатай байх;<br>- үндэсний язгуур эрх ашиг, сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх;<br>- албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх;<br>- хувийн зохион байгуулалт, цаг ашиглалт сайтай байх;<br>- бүтээлч, санаачилгатай ажиллах;</td></tr>
</table>

МОНГОЛ УЛС ЗӨВШӨӨРӨВ ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

| | | |
|---|---|---|
| | | - компьютерын хэрэглээний програм, мэдээллийн технологи ашиглах;<br>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах;<br>- крилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах. |

| **IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ** | |
|---|---|
| Албан тушаалыг шууд харьялан удирдах албан тушаалын нэр:<br>Тархвар зүй, мэдээлэл, судалгаа, статистикийн газрын дарга | |
| Албан тушаалд шууд харьялан удирдуулах албан тушаалын нэр, тоо:<br>- | Бусад харилцах субъект:<br>- Төрийн болон нутгийн удирдлагын байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс<br>- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрүүдийн ажилтан<br>- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага |

| **V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ** | |
|---|---|
| Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан: | Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр: |
| Албан тушаал:<br>АЖЛЫН ХЭСГИЙН ДАРГА Ц.ЦОГЗОЛМАА<br>Ц.Цогзолмаа..........................<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>20 22 оны 07 дугаар сарын 26-ны өдөр | Байгууллагын нэр:<br>ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ<br>Шийдвэрийн огноо: 22 07 07<br>Дугаар: 537 |
| **Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:** | |
| Байгууллагын нэр:<br>МАЛ ЭМНЭЛГИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР<br>Шийдвэрийн огноо: 2022.07.26<br>Дугаар: А/169<br>(тамга/тэмдэг)<br>ДАРГА........................Д.БАТЧУЛУУН<br>(Гарын үсэг) (Эцэг/эх/-ийн нэр, өөрийн нэр)<br>20 22 оны 08 дугаар сарын 02-ны өдөр | |